

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/29/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМАН ДАХЬ МЭРГЭЖИЛ СУРГАЛТ,
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.20 № 01/65
танай _____ -ны № _____ -т
Өөрчлөлтгүй дүгнэлт

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМАН ДАХЬ
МЭРГЭЖИЛ СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ Ш.ОТГОНХҮҮ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоолын дагуу албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосон байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын төслөөс 80,249.0 мянган төгрөгийн гүн өрмийн цэвэршүүлэгчтэй худаг, 98,041.1 мянган төгрөгийн хөргөлтийн агуулах, БНЧУ-ын Засгийн газрын төслөөр 180,042.4 мянган төгрөгийн эрчим хүчний хэмнэлттэй уурын зуух, нийт 358,332.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд тусган тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 22 арга

хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>53,499,395.74</u>	<u>65,564,536.74</u>
33	АВЛАГА	679,600.00	679,600.00
335	Бусад авлага	679,600.00	679,600.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	679,600.00	679,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	52,819,795.74	64,884,936.74
351	Түүхий эд материал	14,930,000.00	14,930,000.00
35110	Тусгай зориулалттай материал	14,930,000.00	14,930,000.00
354	Хангамжийн материал	19,219,795.74	31,654,936.74
35410	Бичиг хэргийн материал	429,090.00	983,090.00
35420	Аж ахуйн материал	9,858,630.00	14,395,152.00
35440	Түлш, шатах тослох материал	1,398,680.76	3,164,015.76
35450	Барилгын засварын материал	3,331,500.00	3,004,400.00
35460	Хүнсний материал	2,488,127.58	4,697,971.58
35470	Бусад хангамжийн материал	1,713,767.40	5,410,307.40
35600	Мал амьтад	18,670,000.00	18,300,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,255,888,779.15</u>	<u>1,633,757,369.08</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,255,888,779.15	1,633,757,369.08
392	Биет хөрөнгө	1,113,058,779.15	1,491,698,969.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	958,396,923.85	1,138,521,123.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	-122,638,795.18	-159,250,772.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	111,235,859.83	111,235,859.83
39204	Хуримтлагдсан элэгдэл	-11,225,001.15	-24,555,430.59
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	608,026,428.40	906,154,782.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-467,363,736.19	-519,956,485.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	119,872,080.66	123,167,080.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-99,468,921.77	-105,796,129.74
39214	Бусад үндсэн хөрөнгө	830,000.00	1,330,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-830,000.00	-830,000.00
39217	Ном	16,223,940.70	21,678,940.70
393	Биет бус хөрөнгө	142,830,000.00	142,058,400.00
39301	Программ хангамж	19,733,000.00	19,733,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-15,875,000.00	-16,646,600.00
39303	Бусад биет бус хөрөнгө	162,128,000.00	162,128,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-23,156,000.00	-23,156,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,309,388,174.89</u>	<u>1,699,321,905.82</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,309,388,174.89</u>	<u>1,699,321,905.82</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,309,388,174.89	1,699,321,905.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	464,952,792.60	464,952,792.60
51101	Өмч: - төрийн	464,952,792.60	464,952,792.60
512	Хуримтлагдсан үр дүн	-365,011,157.03	24,922,573.90
51210	Өмнөх үеийн үр дүн	-365,011,157.03	-365,011,157.03
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	389,933,730.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,209,446,539.32	1,209,446,539.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,309,388,174.89</u>	<u>1,699,321,905.82</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,356,486,620.65	1,761,537,353.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	209,941,320.65	468,245,053.79
120	Нийтлэг татварын бус орлого	209,941,320.65	468,245,053.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	209,941,320.65	468,245,053.79
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,920,000.00	767,699.73
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,250,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	206,771,320.65	467,477,354.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,146,545,300.00	1,293,292,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,146,545,300.00	1,258,812,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,146,545,300.00	1,258,812,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	34,480,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	34,480,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,349,080,729.56	1,363,163,622.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,349,080,729.56	1,363,163,622.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,223,106,261.62	1,206,112,199.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	715,495,794.39	746,649,308.85
210101	Үндсэн цалин	499,946,904.67	491,979,851.00
210102	Нэмэгдэл	137,619,923.46	165,429,880.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,443,997.51	31,605,999.14
210104	Урамшуулал	56,484,968.75	57,633,577.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,549,488.77	96,306,300.00
210201	Тэтгэврийн даатгал	65,319,780.66	67,043,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,239,276.20	7,315,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,710,780.93	5,852,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,389,059.21	1,463,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,890,591.77	14,631,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,970,795.06	87,564,479.00
210301	Гэрэл, цахилгаан	33,899,241.00	35,459,794.00
210302	Түлш, халаалт	46,082,274.06	48,360,185.00
210303	Цэвэр, бохир ус	3,989,280.00	3,744,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	62,390,515.61	17,668,598.00
210401	Бичиг хэрэг	1,936,300.00	2,679,650.00
210402	Тээвэр, шатахуун	2,721,864.50	2,277,570.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,295,838.21	5,135,698.00
210404	Ном, хэвлэл	00.00	1,188,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,996,586.00	2,591,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	786,134.00	3,795,780.00
210408	Бараа материал акталсны зардал	47,653,792.90	00.00
2105	Нормативт зардал	23,614,530.00	41,572,726.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	171,800.00	968,000.00
210502	Хоол, хүнс	23,442,730.00	39,426,426.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,178,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,121,920.65	11,598,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	809,800.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	3,032,600.00
210604	Урсгал засвар	59,312,120.65	8,565,700.00
2107	Томилолт, зочны зардал	72,000.00	1,836,000.00
210702	Дотоод албан томилолт	72,000.00	1,836,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,944,453.28	54,740,062.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,741,057.35	48,675,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,231,995.93	2,232,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,400.00	178,948.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	57,600.00	254,764.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	483,000.00	495,250.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	772,400.00	403,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,946,763.86	148,176,426.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,331,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,452,638.91	35,210,662.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	91,494,124.95	109,633,964.13
2112	ТАТААС	34,248,567.94	00.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	34,248,567.94	00.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	34,248,567.94	00.00
2113	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,725,900.00	157,051,422.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,725,900.00	146,223,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,142,900.00	94,063,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,124,400.00	50,843,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,458,600.00	1,316,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	10,828,222.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	10,828,222.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,405,891.09	398,373,730.93
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,300,000.00	8,440,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	7,300,000.00	8,440,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-7,300,000.00	-8,440,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	105,891.09	389,933,730.93

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,149,715,300.00</u>	<u>1,294,059,999.73</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,170,000.00	767,699.73
120	Нийтлэг татварын бус орлого	3,170,000.00	767,699.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,170,000.00	767,699.73
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,920,000.00	767,699.73
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,250,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,146,545,300.00	1,293,292,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,146,545,300.00	1,258,812,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,146,545,300.00	1,258,812,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	34,480,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	34,480,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,149,715,300.00</u>	<u>1,265,964,799.73</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,149,715,300.00	1,265,964,799.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,023,740,832.06	1,108,913,376.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	715,495,794.39	746,649,308.85
210101	Үндсэн цалин	499,946,904.67	491,979,851.00
210102	Нэмэгдэл	137,619,923.46	165,429,880.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,443,997.51	31,605,999.14
210104	Урамшуулал	56,484,968.75	57,633,577.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,549,488.77	96,306,300.00
210201	Тэтгэврийн даатгал	65,319,780.66	67,043,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,239,276.20	7,315,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,710,780.93	5,852,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,389,059.21	1,463,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,890,591.77	14,631,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,312,714.00	89,329,814.00
210301	Гэрэл, цахилгаан	33,899,241.00	35,459,794.00
210302	Түлш, халаалт	42,424,193.00	50,125,520.00
210303	Цэвэр, бохир ус	3,989,280.00	3,744,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,980,638.21	18,275,800.00
210401	Бичиг хэрэг	1,855,500.00	2,877,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,704,300.00	3,013,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,303,838.21	6,428,300.00
210404	Ном, хэвлэл	00.00	1,188,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	2,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,117,000.00	1,967,600.00
2105	Нормативт зардал	21,643,490.00	46,611,770.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	171,800.00	968,000.00
210502	Хоол, хүнс	19,955,390.00	41,527,770.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,516,300.00	4,116,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	967,800.00	14,398,700.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	807,800.00	900,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	4,928,000.00
210604	Урсгал засвар	160,000.00	8,570,700.00
2107	Томилолт, зочны зардал	72,000.00	1,836,000.00
210702	Дотоод албан томилолт	72,000.00	1,836,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,781,953.28	55,096,012.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,741,057.35	48,675,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,231,995.93	2,232,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,400.00	185,312.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	57,600.00	248,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,333,000.00	495,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	759,900.00	759,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,936,953.41	40,409,672.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	4,131,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,936,953.41	36,277,872.00
212	ТАТААС	34,248,567.94	00.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	34,248,567.94	00.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	34,248,567.94	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,725,900.00	157,051,422.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,725,900.00	146,223,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,142,900.00	94,063,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	42,124,400.00	50,843,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,458,600.00	1,316,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	10,828,222.88
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	10,828,222.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	28,095,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	28,095,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	28,095,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	28,095,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	28,095,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-28,095,200.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	464,952,792.60	176,329,651.15	-217,022,596.42	424,259,847.33
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	464,952,792.60	176,329,651.15	-217,022,596.42	424,259,847.33
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-125,006,979.85	-125,006,979.85
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	464,952,792.60	1,209,446,539.32	-365,011,157.03	1,309,388,174.89
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	464,952,792.60	1,209,446,539.32	-365,011,157.03	1,309,388,174.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	464,952,792.60	1,209,446,539.32	-365,011,157.03	1,309,388,174.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	389,933,730.93	389,933,730.93
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	464,952,792.60	1,209,446,539.32	24,922,573.90	1,699,321,905.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,258,812,300.00	1,248,751,776.85	10,060,523.15	99.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,258,812,300.00	1,248,751,776.85	10,060,523.15	99.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,112,589,000.00	1,102,528,576.85	10,060,423.15	99.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	731,570,700.00	731,259,308.85	311,391.15	99.96
210101	Үндсэн цалин	478,807,500.00	491,979,851.00	(13,172,351.00)	102.75
210102	Нэмэгдэл	160,018,800.00	150,039,880.73	9,978,919.27	93.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,840,000.00	31,605,999.14	(3,765,999.14)	113.53
210104	Урамшуулал	64,904,400.00	57,633,577.98	7,270,822.02	88.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,446,300.00	91,446,300.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	62,183,500.00	62,183,500.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,315,700.00	7,315,700.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,852,600.00	5,852,600.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,463,100.00	1,463,100.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,631,400.00	14,631,400.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,333,300.00	89,329,814.00	3,486.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	33,980,500.00	35,459,794.00	(1,479,294.00)	104.35
210302	Түлш, халаалт	51,608,300.00	50,125,520.00	1,482,780.00	97.13
210303	Цэвэр, бохир ус	3,744,500.00	3,744,500.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,893,500.00	16,870,100.00	23,400.00	99.86
210401	Бичиг хэрэг	1,724,500.00	1,724,500.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	2,513,400.00	2,513,400.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,304,000.00	6,428,300.00	(124,300.00)	101.97
210404	Ном, хэвлэл	1,584,000.00	1,436,300.00	147,700.00	90.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,800,000.00	2,800,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,967,600.00	1,967,600.00	-	100.00
2105	Нормативт зардал	55,607,800.00	46,111,770.00	9,496,030.00	82.92
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	985,600.00	968,000.00	17,600.00	98.21
210502	Хоол, хүнс	50,506,200.00	41,027,770.00	9,478,430.00	81.23
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,116,000.00	4,116,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,398,700.00	14,398,700.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	900,000.00	900,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,928,000.00	4,928,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	8,570,700.00	8,570,700.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,059,400.00	1,836,000.00	223,400.00	89.15
210702	Дотоод албан томилолт	2,059,400.00	1,836,000.00	223,400.00	89.15

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,973,400.00	74,971,212.00	2,188.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,550,600.00	68,550,600.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,232,000.00	2,232,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	185,400.00	85,312.00	88.00	99.95
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	250,500.00	248,400.00	2,100.00	99.16
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	495,000.00	495,000.00	-	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	759,900.00	759,900.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,305,900.00	36,305,372.00	528.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	36,305,900.00	36,305,372.00	528.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,223,300.00	146,223,200.00	100.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	146,223,300.00	146,223,200.00	100.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	94,063,300.00	94,063,300.00	-	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,843,900.00	50,843,900.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,316,100.00	1,316,000.00	100.00	99.99
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,258,812,300.00	1,259,579,999.73	(767,699.73)	100.06
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,258,812,300.00	1,258,812,300.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,258,812,300.00	1,258,812,300.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	767,699.73	(767,699.73)	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	767,699.73	(767,699.73)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	55.00	55.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,480,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,480,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,480,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,390,000.00
210102	Нэмэгдэл	15,390,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,860,000.00
210201	Тэтгэврийн даатгал	4,860,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,653,200.00
210401	Бичиг хэрэг	1,153,200.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00
2105	Нормативт зардал	500,000.00
210502	Хоол, хүнс	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,945,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,945,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,131,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,131,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,480,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,480,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,480,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв нь эрхэм зорилгоо “Стандартад нийцсэн хөдөө аж ахуйн сургалтын шинэлэг орчныг бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлагад нийцсэн, зөв төлөвшилтэй, чадварлаг ажилтан бэлтгэх” гэж тодорхойлсон.

Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь үйл ажиллагааны зорилгоо хөдөлмөрийн зах зээлийн зохистой эрэлт, нийлүүлэлт, төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан чадамжид суурилсан сургалтын цогц үйлчилгээг олон улсын стандартын түвшинд үзүүлэх үндэсний хэмжээний мэргэжилтэн бэлтгэх, сургалтын технологи, агуулга арга зүйд өөрчлөлт хийх, сургалтын орчноо сайжруулах, хүний нөөцийг чадваржуулж, нийгмийн асуудлыг сайжруулах, байгууллагын удирдлагын чадавхыг дээшлүүлж, бүтцэд өөрчлөлт хийх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа
- Мэргэжлийн боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 1а/5063 албан бичгийн хүрээнд Аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/641 дугаар захирамжаар баталсан ажлын хэсэг тус байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 389,933.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	679.60	679.60	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	52,819.79	64,884.93	12,065.14
Үндсэн хөрөнгө	1,255,888.78	1,633,757.37	377,868.59
Нийт хөрөнгийн дүн	1,309,388.17	1,699,321.90	389,933.73
Өглөг	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	464,952.79	464,952.79	-
Хуримтлагдсан үр дүн	(365,011.16)	24,922.57	389,933.73
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,209,446.54	1,209,446.54	-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,309,388.17	1,699,321.90	389,933.73

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,065.1 мянган төгрөгөөр өссөн нь зах зээл бараа материалын үнийн өсөлт бий болсны улмаас түлш халаалт болон дотуур байрны хүүхдийн хоолны материалыг нөөцөлснөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 377,868.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 457,454.8 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,248,751.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж улсын төсвөөс санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 22 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,258,512.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 100 хувь улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,258,812.3 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 767.7 мянган төгрөгийн төвлөрүүлж, урсгал зардалд 1,248,751.8 мянган төгрөгийн зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 10,828.2 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,248,751.8 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 311.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 23.4 мянган төгрөг, нормативд зардал 9,496.0 мянган төгрөг, томилолт зочны зардал 223.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71804-Тусгай мэргэжлийн боловсрол	1,258,812.3	1,294,452.7	(35,640.40)	102.83
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,258,812.3	1,107,201.7	151,610.57	87.96
1.2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	-	146,223.2	(146,223.20)	-
1.3	818006-Дотуур байрны хүүхдийн хоол	-	41,027.8	(41,027.77)	-
Дүн		1,258,812.3	1,294,452.7	(35,640.40)	102.83

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 34,480.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, урсгал үйл ажиллагаанд 34,480.0 мянган төгрөгийн зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж, худалдан авалт бүрийг и-баримтаар баталгаажуулж байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор С.Батжаргал, Н.Тэмүүжин нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 1,258,812.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,882.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох зардлыг хэмнэж цалин хөлс болон нэмэгдэл урамшууллаас 311.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 3.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлаас 23.4 мянган төгрөг, норматив зардлаас 9,496.0 мянган төгрөг, томилолт зочны зардлаас 223.4 мянган төгрөгийг, нийт 10,060.5 мянган төгрөгийн хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 171 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 171 мэдээллээс 162 мэдээллийг хугацаандаа, 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, мөн цалингаас бусад 5 саяас дээш 7,945.0 мянган төгрөгийн 1 ажил гүйлгээ, нийт 5 саяас дээш үнийн дүн бүхий 7 байгууллагын 71,700.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансанд тус тус мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 106.1 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа зөрчил давтан гарч байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	-	-	-	-	-
Төлбөрийн акт	1	106.1	1	106.1	100.0
Зөвлөмж	3	2,038.9	2	2,038.9	66.7
Нийт дүн	4	2,145.0	3	2,145.0	83.4

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,006.8 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 3,433.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 12,573.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 3,433.6 мянган төгрөгийн зөрчил арилгах 2 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд гэрэл цахилгааны зардлыг 1,479.3 мянган төгрөгөөр, шуудан холбоо интернэтийн төлбөрийг 124.3 мянган төгрөгөөр тус тус батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулж, батлагдсан төсөвт зардлыг хэмнэж ажиллаагүй нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацааны хүнсний материалын үлдэгдлийг анхан шатны баримт руу хөөн шалгахад 915 кг буюу 1,830.0 мянган төгрөгийн үнэ бүхий аарц бүртгэлтэй, хүнсний материалыг их хэмжээгээр бэлтгэн нөөцөлсөн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд даатгуулагчаас төлөх 1,408.2 мянган төгрөгийн НДШ-ийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

2. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад нийт 3 харилцагч байгууллагын 11,165.0 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацаанд гэрэл цахилгааны зардлыг 1,479.3 мянган төгрөгөөр, шуудан холбоо интернэтийн төлбөрийг 124.3 мянган төгрөгөөр төсвөөс хэтрүүлэн зарцуулж, батлагдсан төсөвт зардлыг хэмнэж ажиллаагүй	1	1,603.6	-	-	1	1,603.6			-	-	-	-
Тайлант хугацааны хүнсний материалын үлдэгдлийг анхан шатны баримт руу хөөн шалгахад 915 кг, 1,830.0 мянган төгрөгийн үнэ бүхий аарц бүртгэлтэй, хүнсний материалыг их хэмжээгээр бэлтгэн нөөцөлсөн	1	1,830.0	-	-	1	1,830.0			-	-	-	-
Тайлант хугацаанд даатгуулагчаас төлөх 1,408.2 мянган төгрөгийн НДШ-ийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас гүйлгэн зарцуулсан	1	1,408.2	-	-			1	1,408.2	-	-	-	-
Тайлант хугацааны худалдан авалтыг харилцагч байгууллагын цахим төлбөрийн баримттай тулгахад нийт 3 харилцагч байгууллагын 11,165.0 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллаагүй	1	11,165.0	-	-			1	11,165.0	-	-	-	-
Дүн	4	16,006.8	-	-	2	3,433.6	2	12,573.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<u>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</u>										
Шилэн дансанд мэдээлбэл зохих 171 мэдээллээс 162 мэдээллийг хугацаандаа, 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, мөн цалингаас бусад 5 саяас дээш 7,945.0 мянган төгрөгийн 1 ажил гүйлгээ, нийт 5 саяас дээш үнийн дүн бүхий 7 байгууллагын 71,700.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг шилэн дансанд тус тус мэдээлээгүй	1	79,645.7	-	-	-	-	-	-	1	79,645.7
Дүн	1	79,645.7	-	-	-	-	-	-	1	79,645.7

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn